**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2023/01-НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Б.Батмөнх |
| Сүхбаатар сум | Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| 2023 он | Ахлах аудитор: Ц.Отгонбаяр |
| | Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. Аудитын дүгнэлт 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-13

3. Санхүүгийн тайлангийн тодруулга 14-18

    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 14

    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 14

    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 15

    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 15

    3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 16

4. Аудитын тайлан 18-25

    4.1 Ерөнхий зүйл 18

    4.2 Материаллаг байдал 18

    4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 19

    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 19

    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 19

    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 20

5. Аудитын илрүүлэлт 21

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 26


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчийн хурал |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Э.ОЮУНБОЛД ТАНАА

2023-02-25 № СТА-2023/01-НА-СТА-74/3

танай ____________-ны № ______________-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан, батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиг, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулсан, шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн  6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн  13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.6, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дугаар заалтууд болон   Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"- ийг тус тус зөрчсөн байна.

018020327

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн ИТХ-ын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.4 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 3.6 хувиар хэмнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

ИТХ-ын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 49.6 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 239,323.8 мянган төгрөг, намуудын санхүүжилтэд 185,000.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 156,399.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **32,393,761.00** | **47,188,095.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 00.00 | 20,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 32,393,761.00 | 27,188,095.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 32,393,761.00 | 27,188,095.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 18,086,930.00 | 11,242,664.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,125,950.00 | 15,746,550.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,145,881.00 | 94,881.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 35,000.00 | 104,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **39,364,375.97** | **89,781,033.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 39,364,375.97 | 89,781,033.81 |
| **392** | **Биет хөрөнгө** | 39,364,375.97 | 89,781,033.81 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 126,800,000.00 | 126,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -120,549,999.86 | -123,049,999.82 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 92,124,480.00 | 165,284,280.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -75,251,089.72 | -98,400,381.92 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,405,115.20 | 28,244,315.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,164,129.65 | -9,097,179.65 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -880,000.00 | -880,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **71,758,136.97** | **136,969,128.81** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,610,629.54** | **1,688,704.31** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,610,629.54 | 1,688,704.31 |
| **413** | **Өглөг** | 1,610,629.54 | 1,688,704.31 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,610,629.54 | 1,688,704.31 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **70,147,507.43** | **135,280,424.50** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 70,147,507.43 | 135,280,424.50 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 99,213,204.00 | 99,213,204.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 99,213,204.00 | 99,213,204.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -29,065,696.57 | 36,067,220.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -29,065,696.57 | -29,065,696.57 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 65,132,917.07 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **71,758,136.97** | **136,969,128.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **716,567,571.00** | **1,766,795,528.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **148,000.00** | **75,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 148,000.00 | 75,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 148,000.00 | 75,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 148,000.00 | 75,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **716,419,571.00** | **1,691,795,528.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 139,140,000.00 | 453,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 139,140,000.00 | 453,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 577,279,571.00 | 1,238,795,528.75 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 577,279,571.00 | 1,238,795,528.75 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **747,127,086.40** | **1,701,662,611.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **747,127,086.40** | **1,701,662,611.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 434,634,886.40 | 1,059,137,211.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 164,825,166.88 | 548,970,347.75 |
| 210101 | Үндсэн цалин | 94,827,118.60 | 127,531,828.11 |
| 210102 | Нэмэгдэл | 39,819,350.28 | 37,077,918.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,564,751.00 | 3,141,000.00 |
| 210104 | Урамшуулал | 24,613,947.00 | 378,219,600.72 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 3,000,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,761,024.66 | 65,131,316.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,233,824.66 | 46,417,934.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,631,800.00 | 5,377,632.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,305,500.00 | 4,392,826.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 326,300.00 | 621,588.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,263,600.00 | 8,321,334.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 9,154,621.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 3,368,583.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 2,636,038.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 3,150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 72,768,195.00 | 88,788,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,350,370.00 | 38,822,916.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,549,925.00 | 20,666,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,096,434.00 | 1,698,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,040,000.00 | 484,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,919,866.00 | 27,116,984.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,096,500.00 | 29,946,768.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,096,500.00 | 29,946,768.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,758,000.00 | 53,500,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 45,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,758,000.00 | 8,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,104,100.00 | 12,555,092.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 751,092.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,888,000.00 | 11,804,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 98,758,721.00 | 231,830,573.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 96,366,690.00 | 208,405,035.86 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,334,775.00 | 1,574,775.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 422,556.00 | 1,205,763.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 590,700.00 | 601,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,563,178.86 | 39,259,992.16 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 3,919,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,721,850.00 | 7,758,050.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,841,328.86 | 27,582,342.16 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 312,492,200.00 | 642,525,400.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 185,000,000.00 | 185,000,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 185,000,000.00 | 185,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 127,492,200.00 | 457,525,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 120,000,000.00 | 451,205,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,492,200.00 | 6,320,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-30,559,515.40** | **65,132,917.07** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-30,559,515.40** | **65,132,917.07** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **512,149,500.00** | **1,691,795,528.75** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **512,149,500.00** | **1,691,795,528.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 139,140,000.00 | 453,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 139,140,000.00 | 453,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 373,009,500.00 | 1,238,795,528.75 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 373,009,500.00 | 1,238,795,528.75 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **476,264,839.09** | **1,683,796,528.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **476,264,839.09** | **1,683,796,528.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **169,664,839.09** | **1,041,271,128.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 78,240,862.09 | 548,234,896.89 |
| 210101 | Үндсэн цалин | 49,472,289.53 | 127,268,002.80 |
| 210102 | Нэмэгдэл | 16,422,112.56 | 36,606,293.37 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,236,460.00 | 3,141,000.00 |
| 210104 | Урамшуулал | 10,110,000.00 | 378,219,600.72 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 3,000,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,994,200.00 | 65,788,693.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,730,000.00 | 45,709,878.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 816,200.00 | 5,377,632.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 652,600.00 | 4,641,466.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 163,600.00 | 621,588.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,631,800.00 | 9,438,127.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 9,154,621.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 3,368,583.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 2,636,038.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 3,150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,007,438.00 | 52,111,312.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,208,000.00 | 6,145,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 18,585,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 924,508.00 | 1,698,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 948,000.00 | 840,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,426,930.00 | 24,841,862.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,161,200.00 | 29,946,768.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,161,200.00 | 29,946,768.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,914,000.00 | 53,500,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 45,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,914,000.00 | 8,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,819,400.00 | 12,555,092.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 751,092.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,542,000.00 | 11,804,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42,620,239.00 | 251,323,845.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,416,308.00 | 247,898,307.86 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,334,775.00 | 1,574,775.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 422,556.00 | 1,205,763.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 402,600.00 | 601,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,907,500.00 | 18,655,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 9,811,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,907,500.00 | 8,844,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **306,600,000.00** | **642,525,400.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 185,000,000.00 | 185,000,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 185,000,000.00 | 185,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 121,600,000.00 | 457,525,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 120,000,000.00 | 451,205,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,600,000.00 | 6,320,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **35,884,660.91** | **7,999,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **7,999,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **7,999,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 7,999,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 7,999,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-7,999,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 99,213,204.00 | 00.00 | 24,621,683.84 | 123,834,887.84 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **99,213,204.00** | **00.00** | **24,621,683.84** | **123,834,887.84** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -5,132,366.85 | -5,132,366.85 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **99,213,204.00** | **00.00** | **-29,065,696.57** | **70,147,507.43** |
| **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **99,213,204.00** | **00.00** | **-29,065,696.57** | **70,147,507.43** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **99,213,204.00** | **00.00** | **-29,065,696.57** | **70,147,507.43** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 65,132,917.07 | 65,132,917.07 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **99,213,204.00** | **00.00** | **36,067,220.50** | **135,280,424.50** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,285,708,400.00 | 1,238,795,528.75 | 46,912,871.25 | 96.35 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,285,708,400.00 | 1,238,795,528.75 | 46,912,871.25 | 96.35 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,084,183,000.00 | 1,037,270,128.75 | 46,912,871.25 | 95.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 577,400,000.00 | 548,234,896.89 | 29,165,103.11 | 94.95 |
| 210101 | Үндсэн цалин | 120,000,000.00 | 127,268,002.80 | -7,268,002.80 | 106.06 |
| 210102 | Нэмэгдэл | 46,200,000.00 | 36,606,293.37 | 9,593,706.63 | 79.23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,480,000.00 | 3,141,000.00 | 3,339,000.00 | 48.47 |
| 210104 | Урамшуулал | 404,720,000.00 | 378,219,600.72 | 26,500,399.28 | 93.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,219,400.00 | 65,788,693.00 | 8,430,707.00 | 88.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,123,400.00 | 45,709,878.14 | 5,413,521.86 | 89.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,774,000.00 | 5,377,632.72 | 396,367.28 | 93.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,904,300.00 | 4,641,466.19 | 262,833.81 | 94.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,154,800.00 | 621,588.71 | 533,211.29 | 53.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,262,900.00 | 9,438,127.24 | 1,824,772.76 | 83.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,550,000.00 | 9,154,621.00 | 395,379.00 | 95.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,600,000.00 | 3,368,583.00 | 231,417.00 | 93.57 |
| 210302 | Түлш, халаалт | 2,800,000.00 | 2,636,038.00 | 163,962.00 | 94.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,150,000.00 | 3,150,000.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,960,900.00 | 52,111,312.00 | 849,588.00 | 98.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,500,000.00 | 6,145,850.00 | 354,150.00 | 94.55 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,585,000.00 | 18,585,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,708,900.00 | 1,698,600.00 | 10,300.00 | 99.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 840,000.00 | 840,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,327,000.00 | 24,841,862.00 | 485,138.00 | 98.08 |
| **2105** | **Нормативт зардал** | 29,950,000.00 | 29,946,768.00 | 3,232.00 | 99.99 |
| 210502 | Хоол, хүнс | 29,950,000.00 | 29,946,768.00 | 3,232.00 | 99.99 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 61,660,000.00 | 61,499,000.00 | 161,000.00 | 99.74 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 48,660,000.00 | 48,659,800.00 | 200.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 4,839,200.00 | 160,800.00 | 96.78 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,001,100.00 | 12,555,092.00 | 446,008.00 | 96.57 |
| 210701 | Гадаад албан томилолт | 751,100.00 | 751,092.00 | 8.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,250,000.00 | 11,804,000.00 | 446,000.00 | 96.36 |
| 210703 | **Зочин төлөөлөгч хүлээн авах** | | | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 246,096,600.00 | 239,323,845.86 | 6,772,754.14 | 97.25 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 242,583,900.00 | 235,898,307.86 | 6,685,592.14 | 97.24 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Аудит, баталгаажуулалт | | | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,575,000.00 | 1,574,775.00 | 225.00 | 99.99 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,235,000.00 | 1,205,763.00 | 29,237.00 | 97.63 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 44,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 658,700.00 | 601,000.00 | 57,700.00 | 91.24 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19345000.00 | 18655900.00 | 689,100.00 | 96.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,500,000.00 | 9,811,600.00 | 688,400.00 | 93.44 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,845,000.00 | 8,844,300.00 | 700.00 | 99.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **201525400.00** | **201525400.00** | **0.00** | **100.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 185,000,000.00 | 185,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 185,000,000.00 | 185,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,525,400.00 | 16,525,400.00 | 0.00 | 100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,205,400.00 | 10,205,400.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,320,000.00 | 6,320,000.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,285,708,400.00 | 1,238,795,528.75 | 46,912,871.25 | 96.35 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,285,708,400.00 | 1,238,795,528.75 | 46,912,871.25 | 96.35 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,285,708,400.00 | 1,238,795,528.75 | 46,912,871.25 | 96.35 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **453,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **453,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 12,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 441,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 441,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 441,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **453,000,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 453,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 453,000,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /*цаашид аймгийн ИТХ гэх*/ нь *"Хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлдэг Сэлэнгэ нутгийн ард иргэдийн итгэлийг хүлээсэн хариуцлагатай төлөөллийн байгууллага байна."* гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хурлын зохион байгуулалт үйл ажиллагааг сайжруулах,
- Хурлын болон тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, бодлого зорилтыг тодорхойлох,
- Хууль, тогтоомж хурлын болон тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн биелэлтийн явцыг хянан шалгах, үр дүнг тооцох ажлыг сайжруулах,
- Хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, ил тод нээлттэй байдлыг эрхэмлэх,
- Аймаг, сумдын эдийн засаг, санхүүгийн чадавхыг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх,
- Эрүүл мэнд, боловсрол, соёл , спортын байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлж иргэдийн амьжиргааны чадавхыг дээшлүүлэх,
- Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжүүлэх бодлого зорилтыг тодорхойлж бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хүртээмж чанарыг сайжруулах,
- Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг, дэвшилтэд технологи, тэнцвэртэй харьцаа, зөв зохицлоор эрчимтэй хөгжүүлэх,
- Байгаль, орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдол, доройтлыг бууруулах, зохистой ашиглах,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах ажлыг эрчимжүүлэн, иргэдийн амгалан тайван, аюулгүй ажиллах амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,

- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт, үр нөлөө сул гэж үзлээ.

Аймгийн ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт, аудит хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталсныг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,211.0 мянган төгрөгөөр буюу 90.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилж гарсан зардал | | 20,000.00 | 20,000.00 |
| Бараа материал | 32,393.70 | 27,188.10 | (5,205.60) |
| Үндсэн хөрөнгө | 39,364.40 | 89,781.00 | 50,416.60 |
| **Нийт хөрөнгө** | **71,758.10** | **136,969.10** | **65,211.00** |
| Өр төлбөр | 1610.6 | 1688.7 | 78.10 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 70,147.50 | 135,280.40 | 65,132.90 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **71,758.10** | **136,969.10** | **65,211.00** |

Тайлант оны эцэст урьдчилж гарсан зардал 20,000.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ойд зориулж нэвтрүүлэг бэлтгэх, телевиз болон сошиал хуудсаар цацах ажлын санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн боловч бүрэн хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27,188.1 мянган төгрөг болж 5,205.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 125,161.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон аймгийн хөрөнгө оруулалтаар 5,000.0 мянган төгрөгийн хүндэт тэмдэг үнэ төлбөргүй хүлээн авч, 135,367.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 321,208.6 мянган төгрөг болж 77,999.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,999.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, 70,000.0 мянган төгрөгийн Ipad-ыг аймгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 136,969.1 мянган төгрөг болж 65,211.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,349,626.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 498,497.8 мянган төгрөгөөр бууруулж / *цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 28,245.9 мянган төгрөгөөр, төлөөлөгчдийн*

*урамшууллын зардлыг 402,560.0 мянган төгрөгөөр бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./* 851,128.4 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 434,580.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна. Үүнд:

- *Төлөөлөгчдийн урамшууллын зардлыг 419,580.0 мянган төгрөгөөр,*
- *Бараа үйлчилгээний бусад зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж,*
- *Гадаад томилолтын зардлыг 3,750.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардлыг 4,250.0 мянган төгрөгөөр,*
- *Урсгал засварын зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.*

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,285,708.4 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,238,795.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,238,795.5 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 46,912.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 298,356.50 | 290,460.00 | 7,896.50 | 97.4 |
| 2 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 28,900.00 | 28,900.00 | 0.00 | 100.0 |
| 3 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 41,758.90 | 35,605.00 | 6,153.90 | 85.3 |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 6,320.00 | 6,320.00 | 0.00 | 100.0 |
| 5 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор | 10,205.40 | 10,205.40 | 0.00 | 100.0 |
| 6 | ИТХ-д суудалтай намуудад олгох санхүүжилт | 185,000.00 | 185,000.00 | 0.00 | 100.0 |
| 7 | Ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээ | 508,237.60 | 476,656.10 | 31,581.50 | 93.8 |
| 8 | Гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа | 50,000.00 | 49,249.30 | 750.70 | 98.5 |
| 9 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 156,930.00 | 156,399.70 | 530.30 | 99.7 |
| | **Дүн** | **1,285,708.40** | **1,238,795.50** | **46,912.90** | **96.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130050001 тоот дансанд онд Цагаатгалын улсын комиссоос 441,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 12,000.0 мянган төгрөг зэрэг нийт 453,000.0 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,721,662.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,216.6

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Тайлант оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс Хурлын даргын зөвлөхөөр ажиллаж байсан Ж.Санжжавын гэрээг цуцалж, урамшууллын зардлыг хэмнэсэн,
- Ажлын албаны нарийн бичгийн дарга хот дотор суудлын автомашин ашиглалгүйгээр шатахууны зардлыг хэмнэсэн.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 163-г хугацаанд нь мэдээлсэн бол 7-р сард дараах 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- *Байгууллагын батлагдсан төсөв /бүтэн жилээр/*
- *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт /тухай бүр/*
- *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)*
- *Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)*

*Шийдвэрлэсэн нь :* Зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн

бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан бөгөөд 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

*Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 15,979.3 | | | |
| Зөвлөмж | 2 | 71,611.6 | 1 | 5,568.0 | 50.0 |
| **Нийт дүн** | **3** | **87,590.9** | 1 | 5,568.0 | **33.3** |

Өмнөх аудитаар өгсөн батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, өр төлбөр үүсгэсэн зэрэг зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1-т *"...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"* гэсэн заалтын дагуу холбогдох албан тушаалтанд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын батлагдсан төсөвтэй холбоотой дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Тус газрын төсөвт үндсэн чиг үүрэгт хамааралгүй Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн зардалд 45,500.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 156,399.7 мянган төгрөгийн төсөв баталсан байгаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д *"Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана."*, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3[1], 46.6[2] дахь заалт болон Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан *"Гэмт хэргээс*

[1] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.

[2] Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг зөрчлийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг харгалзан асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тухай бүр тусгаж, зарцуулна.

*урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам*"-ын 1.5[3], 2.7[4] дахь заалтуудтай нийцэхгүй байна. Аймгийн ИТХ нь дээрх асуудалтай холбоотой бодлогыг тодорхойлж, тухайн арга хэмжээний зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага юм. Иймд цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн зардал болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг аймгийн Засаг даргын ерөнхий дансанд баталж байх шаардлагатай .

- Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д "*УИХ-д суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор УИХ-ын гишүүний нэг суудлыг жилд 10,000.0 мянган төгрөгөөр тооцож, УИХ-ын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно*" гэж заасан атал аймгийн ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс **185,000.0 мянган** төгрөгийн дэмжлэг олгохоор аймгийн ИТХ-ын төсөвт тусган баталж, зарцуулдаг зөрчил он дамжин давтагдсан байна.

[3] Батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан сум, дүүргийн төсөвт олгосон хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн нэрээр тусгай дансанд төвлөрүүлнэ.
[4] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад Нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ойд зориулж нэвтрүүлэг бэлтгэх, телевизор болон сошиал хуудсаар цацах ажилд 20,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тайлант онд бүрэн хэрэгжээгүй тул урьдчилж гарсан зардлаар бүртгүүлж залрууллаа.

Аудитаар нийт 129,693.3 мянган төгрөгийн зөрчил[5] илэрч албан шаардлага хүргүүлсэн бөгөөд 3 зөрчилд зөвлөмж өгөв.

### 5.1 Албан шаардлага

*1.* Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 1,424.8 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 263.8 мянган төгрөгийн зэрэг нийт 1,688.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал болон хуралдааны зардлаас зочин, төлөөлөгчийн бэлэг худалдан авахад 1,209.0 мянган төгрөг, гэрэл, цахилгааны зардлаас тоолуур худалдан авахад 968.0 мянган төгрөг буюу нийт 2,177.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь :* Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх *"...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"* гэсэн заалтын дагуу холбогдох албан тушаалтанд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашиггүйгээр зарцуулж, дараах ажил гүйлгээг гүйцэтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх " *Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх *" ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор ... салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх*",

[5] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

15.1.6 дахь *“... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх* “гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Дэлхийн чимээ медиа групп ХХК-тай *“Нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ойд зориулж нэвтрүүлэг бэлтгэж, Live TV HD телевизорын эфир болон сошиал хуудсаар цацах”* гэрээ байгуулж, 20,000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч тайлант онд гэрээт ажил бүрэн хэрэгжээгүй, авлага үүсгэсэн,
- Хууль, эрх зүйн эмхэтгэлийг бодит хэрэгцээнд тохируулж цөөн тоогоор хэвлүүлэх, цахим хэлбэрээр архив үүсгэх зэргээр төсвийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулалгүйгээр 12 дугаар сард тогтоол, шийдвэрийн эмхэтгэл хэвлүүлэхэд 6,980.0 мянган төгрөг, мөрдөгч хүүхэд сэтгүүлд 2,850.0 мянган төгрөг, цаасан тор хэвлүүлэхэд 3,258.5 мянган төгрөг буюу нийт 13,088.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

*Шийдвэрлэсэн нь :* Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Шууд худалдан авах босго үнээс давсан гал түймэр унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах 31,000.0 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр гүйцэтгэсэн байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”* ,Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”* -ийг тус тус зөрчсөн байна.
*Шийдвэрлэсэн нь:* Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4.Ажилласан цагийн бүртгэлтгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр аймгийн ИТХ-ын дарга Ц.Нарантуяад 12 дугаар сард 1,941.8 мянган төгрөгийн цалин олгож, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх. Тогтоов.

5. Гэрээт ажилтны орон тоо батлагдаагүй байхад мэдээлэл технологийн сүлжээний инженерээр Ч.Гандүүрэнг ажиллуулж 1,200.0 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь *“Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”* 16.5.3 дахь *“батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн*

*байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хязгаарт багтаан орон тоо, цалин хөлсийг тогтоож байх албан шаардлага хүргүүлэв.

6. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 58,597.4 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д *"Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ..." гэж заасныг зөрчсөн байна.*

*Шийдвэрлэсэн нь :* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*", 4.2.1.10: "*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал***

**1.1** Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ын хавсралтад заасан зардлын ангилал нэр төрлөөр бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, хянах зарчмыг алдагдуулж байна.

**1.2** Өгсөн зөвлөмж: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж байх.

**2. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал**

**2.1** Илрүүлэлт: 2016-2020 оны ИТХ-ын төлөөлөгчдийн албан хэрэгцээнд ашиглаж байсан, элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй, төлөөлөгчдөөс буцаан аваагүй буюу бодитоор байхгүй 37 ширхэг Ipad-ыг тус байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх *"Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна."*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1-д *"үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын*

*дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх,....”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Оршин байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2** Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг актлах эсвэл дахин үнэлж албан хэрэгцээнд ашиглах эсэх шийдвэрийг хууль журамд нийцүүлэн гаргаж, үр дүнг бүртгэл тайланд тусгах.

**3. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой.**

**3.1** Илрүүлэлт: Хурлын төлөөлөгчдийн хоол, зочид буудлын зардлыг гүйцэтгэлээр бус төлөвлөсөн дүнгээр Шинэбадрах, Номадсрэзидэнс, Гүнж аялгуу зэрэг компаниудад шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,* 13.7 дэх *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.
**3.2** Өгсөн зөвлөмж: Төлөөлөгчдийн хоол, зочид буудлын зардлыг гүйцэтгэлээр тооцож, шилжүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан. | 1 | 3,865.6 | | | 1 | 3,865.6 | | | 1 | 2 | | |
| Батлагдсан төсвийг зориулалт бусаар, арвилан хэмнэлт, үр ашиггүйгээр зарцуулж, ажил гүйлгээг гүйцэтгэсэн | 1 | 33,088.5 | | | 1 | 33,088.5 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй. | 1 | 31,000.0 | | | 1 | 31,000.0 | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн | 1 | 1,941.8 | | | 1 | 1,941.8 | | | | | | |
| Төсөвт тусгагдаагүй орон тоог гэрээгээр гүйцэтгүүлсэн | 1 | 1,200.0 | | | 1 | 1,200.0 | | | | | | |
| Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан | 1 | 58,597.4 | | | 1 | 58,597.4 | | | | | | |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөлгүйгээр зарцуулсан. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг бодитой хийгээгүй. | 1 | | | | | | 1 | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хоол, зочид буудлын зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **9** | **129,693,3** | | | **6** | **129,693,3** | **3** | | **1** | **2** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроосон | 4 | | | | | | 4 | |
| **Дүн** | **4** | | | | | | **4** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **4** | | | | | | **4** | |